210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,940,000.00	4,841,000.00	4,841,000.00	0
210104	Урамшуулал	94,359,300.00	83,834,143.00	83,834,143.00	0
210105	Гэрээт ажлын хөлс	1,400,000.00	1,000,000.00	1,000,000.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	216,993,500.00	202,279,859.02	202,279,859.02	0
210201	Тэтгэврийн даатгал	157,015,900.00	142,975,194.22	142,975,194.22	0
210202	Тэтгэмжийн даатгал	14,994,400.00	15,069,242.11	15,069,242.11	0
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,995,400.00	12,056,333.40	12,056,333.40	0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,999,000.00	2,916,077.67	2,916,077.67	0
210205	Эрүүл мэндийн даатгал	29,988,800.00	29,263,011.62	29,263,011.62	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	249,535,800.00	246,063,678.00	246,063,678.00	0
210301	Гэрэл, цахилгаан	23,336,900.00	16,611,156.00	16,611,156.00	0
210302	Түлш, халаалт	211,932,900.00	214,615,736.00	214,615,736.00	0
210303	Цэвэр, бохир ус	14,266,000.00	14,836,786.00	14,836,786.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	75,649,100.00	72,673,000.00	72,673,000.00	-2,000,000.00
210401	Бичиг хэрэг	5,072,800.00	4,887,700.00	4,887,700.00	0
210402	Тээвэр, шатахуун	35,621,500.00	32,830,500.00	32,830,500.00	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,794,000.00	8,794,000.00	8,794,000.00	0
210404	Ном, хэвлэл	1,517,400.00	1,517,400.00	1,517,400.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,009,100.00	7,009,100.00	7,009,100.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,634,300.00	17,634,300.00	17,634,300.00	-2,000,000.00
2105	Нормативт зардал	131,245,000.00	127,042,224.00	127,042,224.00	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,730,100.00	19,072,324.00	19,072,324.00	0
210502	Хоол, хүнс	104,284,100.00	104,284,100.00	104,284,100.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,230,800.00	3,685,800.00	3,685,800.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,025,300.00	37,025,300.00	37,025,300.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,214,100.00	16,214,100.00	16,214,100.00	0
210604	Урсгал засвар	20,811,200.00	20,811,200.00	20,811,200.00	0
2107	Томиллолт, зочны зардал	7,751,200.00	7,020,700.00	7,020,700.00	0
210702	Дотоод албан томиллолт	7,751,200.00	7,020,700.00	7,020,700.00	0

**Сант сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,033,600.00</b>	<b>4,579,376.00</b>	<b>4,579,376.00</b>	<b>0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,047,800.00	3,047,800.00	3,047,800.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	774,000.00	324,000.00	324,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	590,000.00	590,000.00	590,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,700.00	416,700.00	416,700.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	76,800.00	76,800.00	76,800.00	0
210807	Газрын төлбөр	128,300.00	124,076.00	124,076.00	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>146,198,900.00</b>	<b>127,949,330.00</b>	<b>127,949,330.00</b>	<b>-1,800,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	137,200,500.00	118,950,930.00	118,950,930.00	-1,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,998,400.00	8,998,400.00	8,998,400.00	0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,113,800.00</b>	<b>39,113,800.00</b>	<b>39,113,800.00</b>	<b>0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,113,800.00</b>	<b>39,113,800.00</b>	<b>39,113,800.00</b>	<b>0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	442,000.00	442,000.00	442,000.00	0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,744,500.00	36,744,500.00	36,744,500.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,927,300.00	1,927,300.00	1,927,300.00	0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>133,390,800.00</b>	<b>116,293,239.00</b>	<b>116,293,239.00</b>	<b>0</b>
223001	Бусад хөрөнгө	133,390,800.00	116,293,239.00	116,293,239.00	0
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>120,000,000.00</b>	<b>471,000.00</b>	<b>471,000.00</b>	<b>0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	120,000,000.00	471,000.00	471,000.00	0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,734,259,600.00</b>	<b>2,727,570,176.00</b>	<b>2,768,143,576.00</b>	<b>-40,573,400.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,616,256,900.00</b>	<b>1,616,256,900.00</b>	<b>2,390,278,700.00</b>	<b>-774,021,800.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	774,021,800.00	-774,021,800.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,616,256,900.00	1,616,256,900.00	1,616,256,900.00	0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>870,377,600.00</b>	<b>901,557,200.00</b>	<b>96,355,800.00</b>	<b>805,201,400.00</b>
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	96,355,800.00	96,355,800.00	96,355,800.00	0
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>36,847,300.00</b>	<b>29,219,300.00</b>	<b>29,219,300.00</b>	<b>0</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36,847,300.00	29,219,300.00	29,219,300.00	0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>210,777,800.00</b>	<b>180,536,776.00</b>	<b>252,289,776.00</b>	<b>-71,753,000.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	99,200,000.00	115,856,776.00	115,856,776.00	0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,760,000.00	64,680,000.00	64,680,000.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	71,817,800.00	0	71,753,000.00	-71,753,000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6</b>	<b>6</b>		<b>6</b>
610001	Төсвийн байгууллага	6	6		6
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0		0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>132</b>	<b>132</b>		<b>132</b>
620001	Удирдах ажилтан	13	13		13
620002	Гүйцэтгэх ажилтан	81	81		81
620003	Үйлчлэх ажилтан	38	38		38
620004	Гэрээт ажилтан	0	0		0
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>838</b>	<b>838</b>		<b>838</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>589</b>	<b>589</b>		<b>589</b>
630001	Төрийн өмчит ЕБС	589	589		589
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>249</b>	<b>249</b>		<b>249</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	249	249		249
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>132</b>	<b>132</b>		<b>132</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10		10
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16	16		16
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	94	94		94
650010	Гэрээт ажилтан	1	1		1
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8		8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>208,188,475.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>208,188,475.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>176,300,136.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>42,198,303.07</b>
210101	Үндсэн цалин	19,721,845.23
210102	Нэмэгдэл	22,476,457.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>298,202.76</b>
210201	Тэтгэврийн даатгал	298,202.76
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,109,888.00</b>
210401	Бичиг хэрэг	483,242.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,451,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,140,246.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>93,838,436.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,980,886.00
210502	Хоол, хүнс	13,857,550.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>233,363.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	233,363.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>329,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	329,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>34,492,544.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,492,544.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>800,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,888,338.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,600,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,600,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,288,338.17</b>
213303	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,288,338.17
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>208,188,475.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>208,188,475.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,452,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,260,075.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	165,476,300.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сант сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.16-наас 2022.03.20-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.15-ны өдрийн 38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 6 төсөвт байгууллага, 3 сан, 1 ерөнхий орлогын данс нийт 10 тайлан нэгтгэгджээ.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сант сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 3 тэрбум 866.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 38.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 29.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	129.3	404.8	275.5
31211	Төрийн сангийн харилцах	129.3	404.8	275.5

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 275.5 сая төгрөгөөр өссөн байна.

Дараах байгууллагуудын данс мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.



Created with Datawrapper

#### 3.5.2 Авлага

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
33	АВЛАГА	291.2	309.2	18	100
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2.7	0.4	-2.3	0.13
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3.1	94.7	91.6	30.63
33400	Зээлийн хүүгийн авлага	13.2	5.4	-7.8	1.75
33401	Дансны авлага	8.6		-8.6	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	363.6	208.7	-154.9	67.50

Тайлант оны нийт авлагын 67.5 хувийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь ЭХСангаас олгосон өвс тэжээлийн авлага 114.1 сая төгрөг, СХСангаас олгосон зээлийн авлага 94.6 сая төгрөг байна.

Сумын ЭМТөв ЭМД-ын сангаас 94.7 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

#### 3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 83.3 сая төгрөгөөр өссөн байна.

**Сант сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
35	БАРАА МАТЕРИАЛ	364.6	447.9	83.3	100
351	Түүхий эд материал	31.5	82.6	51.1	18.4
354	Хангамжийн материал	312.1	337.4	25.3	75.3
35500	Биологийн хөрөнгө	18.9	23.5	4.6	5.2
35600	Мал амьтад	2.1	4.4	2.3	1.0
36	НӨӨЦИЙН БАРАА		3	3	

Тайлант онд бараа материалын үлдэгдэл ЭМТөвд 71.5 сая төгрөгөөр өссөн нь ковидын эмчилгээ үйлчилгээтэй холбоотой эм боох материал, тусгай зориулалттай материалын үлдэгдэл нэмэгдсэн нь гол нөгөөг үзүүлсэн байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2 тэрбум 46.6 сая төгрөгөөр өссөн байна.

Код	Үзүүлэлт	Хөрөнгийн дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	<b>5,662.5</b>
2	Нэмэгдсэн	<b>2,202.30</b>
201	Худалдан авсан	19.90
202	Хандиваар	18.10
203	Шилжүүлэн авсан	-
205	Бусад	2,068.10
206	Дахин үнэлгээний нэмэгдэл	96.20
3	Хасагдсан	<b>155.80</b>
303	Шилжүүлсэн	9.40
305	Бусад	14.5
306	Дахин үнэлгээний хорогдол	131.90
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	<b>7,709.10</b>

Сант сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 2 тэрбум 202.3 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 19.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 2 тэрбум 182.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 9.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, 14.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 131.9 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэхээр данснаас хассан байна.

Тайлант онд сумын хэмжээнд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1 тэрбум 602.5 сая төгрөгийн барилга байгууламжийг үнэ төлбөргүйгээр авсан, 16.6 сая төгрөгөөр тээврийн хэрэгсэл, 136.7 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 54.1 сая төгрөгөөр тавилга эд хогшил, 2.2 сая төгрөгөөр ном, 1.0 сая төгрөгөөр программ хангамж, 388.9 сая төгрөгөөр бусад хөрөнгийг тус тус бэлтгэсэн байна.

### 3.5.5 Өр төлбөр

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3.7	111.4	107.7	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3.7	111.4	107.7	100
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.6	66.7	66.1	59.9
41361	Байгууллагад төлөх өглөг	3.1	44.6	41.5	40.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		0.1	0.1	0.1

Тайлант онд өр төлбөр 107.7 сая төгрөгөөр өссөн нь ЭМТөв ажилчдын цалинд 66.7 сая төгрөгийн өртэй, байгууллагад 27.6 сая төгрөгийн эм болон бараа материалын өртэй гарсантай холбоотой байна. Мөн ОНХСан 16.1 сая төгрөг, цэцэрлэг 0.2 сая төгрөг, ЭХСан 0.7 сая төгрөгийн өртэй гарсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

#### 3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 02/02 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 77.8 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 280.7 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 202.9 сая төгрөгөөр даваж биелэсэн байна.

Энэ нь төлөвлөгдөөгүй малд ногдуулах албан татвар 69.9 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны татвар 136.5 сая төгрөгөөр илүү төвлөрсөнтэй холбоотой байна.

Төлөвлөгдсөн татвараас үйл ажиллагааны орлого 25 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 10.5 хувиар, газрын төлбөр 21.5 хувиар, хүү торгуулийн орлого 34.8 хувиар тасарсан байна.

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	27,000	20,365	(6,635)	75.4
2	Хөрөнгийн орлого	34,161	34,324	163	100.5
3	Хөрөнгө борлуулсны орлого		4,667	4,667	
4	Бууны албан татвар	1,080	1,050	(30)	97.2
5	Улсын тэмдэгтийн хураамж	2,040	1,826	(214)	89.5
6	Түгээмэл тархцатай АМНАТ	600	600	-	100.0
7	Хог хаягдлын хураамж	5,570	6,515	945	117.0
8	Газрын төлбөр	820	636	(184)	77.5
9	Малд ногдуулах татвар		69,950	69,950	
10	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		136,512	136,512	
11	Нохойны татвар			-	
12	Ой			-	
	<b>Татварын орлого</b>	<b>71,271</b>	<b>276,446</b>	<b>205,175</b>	<b>387.9</b>
1	Татварын бус/ Хүү, торгуулийн орлого	6,500	4,241	(2,260)	65.2
	<b>Нийт дүн орлого</b>	<b>77,771</b>	<b>280,686</b>	<b>202,915</b>	<b>360.9</b>

#### 3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 2 тэрбум 734.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1 тэрбум 616.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 870.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 36.8 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 210.8 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1 тэрбум 616.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 901.5 сая төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 29.2 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 180.5 сая төгрөг, нийт 2 тэрбум 727.6 сая төгрөгийн санхүүжилт, болон орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 2 тэрбум 388.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 116.3 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 0.5 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 39.1 сая төгрөгийг зарцуулжээ.

#### Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 208.2 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 176.3 сая төгрөг, урсгалд шилжүүлэгт 31.9 сая төгрөг зарцуулжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сант сумын Төрийн сан нь 2021 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар Төрийн сантай холбоотой зөрчил илрээгүй.

#### **3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол**

Төлөвлөлтийн шатанд 5.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

#### 4. Аудитын илрүүлэлт

Сант сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

##### 4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 8 байгууллагын 1 байгууллагад дүгнэлт гаргаж, /ИТХ / 7 байгууллагыг түүвэрт хамруулсан./ ЗДТГ, ИТХ, Цэцэрлэг, ЕБС, ЭМТөв, Соёлын төв, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр **19.2** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 16.2 сая төгрөгийн 4 албан шаардлага, 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж **6.7** сая төгрөгийн зөрчил илэрсэн. ЕБСургуульд- 0.9 сая төгрөгөөр уралдаан тэмцээн зохион байгуулсан,

ЗДТГазарт- 5.2 сая төгрөгөөр эд хогшил худалдан авсан

ИТХ-д- Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 200.0 мянган төгрөгөөр, бусад бараа үйлчилгээний зардлаас 350.0 мянган төгрөгөөр нормын хувцас худалдан авсан.

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой Соёлын төвд- Бараа материалын тайланг батлагдсан маягтаар сар бүр гаргаагүй хагас бүтэн жилээр гаргасан, НББ-ийн бодлогын баримт бичиг байхгүй дараах алдаа зөрчил илэрсэн. Үүнд:
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор Ажил гүйцэтгэгч талтай шууд гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй байна.
- Нийцлийн аудитаар ЕБСургуульд илэрсэн зөрчил Шилэн дансанд **12.5** сая төгрөгийн мэдээлэл дутуу байршуулсан, 19 мэдээлэл хугацаа хоцорсон байна

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Сант сумын Төрийн сан	0	0	0	00	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР

